

China Yangtze Power Co., Ltd. (CYPC)

/600900.SSE/

Компанийн тухай

China Yangtze Power Co., Ltd. (CYPC) нь БНХАУ-ын төрийн өмчит Хятадын Гурван Хавцал Корпорацийн (СТГ) үндсэн хөрөнгө оруулалттайгаар 2002 оны 9-р сарын 29-нд хязгаарлагдмал хариуцлагатай компани болж үйл ажиллагаагаа эхэлжээ.

Тус компани нь 2003 оны 11-р сард Шанхайн Хөрөнгийн Биржид бүртгэгдсэн бол 2020 оны 9-р сард Лондонгийн хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй болсон.

CYPC нь сэргээгдэх эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дэлхийн хамгийн том усан цахилгаан эрчим хүч нийлүүлэгч гэдгээрээ алдартай. Одоогийн байдлаар Хятад, Перу, Бразил, Пакистан гэх мэт нийт 6 улс орнуудад үйл ажиллагаа эрхэлж зөвлөгөө туслалцаа үзүүлдэг. CYPC нь дэлхийн хамгийн том сэргээгдэх эрчим хүчний коридорыг бүрдүүлдэг Вүдүндэ, Байхэтан, Шилуоду, Шяньжяба, Гурван Хавцал, Гэжөүба зэрэг зургаан каскадын усан цахилгаан станцыг удирдан ажиллуулахын зэрэгцээ Хөх мөрний сав газрын үерийн хяналт, навигаци, усан хангамж, экологийн аюулгүй байдлыг үр дүнтэй хянан зохицуулж байгаа нь Хятадын эдийн засаг болон нийгэм дэх ногоон хөгжилд томоохон түлхэц болдог байна.

2022 оны 5-р сарын 4-ний байдлаар л гэхэд, CYPC-ийн харьяа Вүдүндэ, Байхэтан, Шилуоду, Шяньжяба, Гурван Хавцал, Гэжөүба зэрэг зургаан каскадын усан цахилгаан станц нь өнгөрсөн жилүүдэд 3 триллион кВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн нь нүүрсний хэрэглээг 910 сая тонноор хэмнэж, нүүрстөрөгчийн ялгарлыг 2.4 тэрбум орчим тонноор бууруулсантай тэнцэж байгаа юм.

Түүнээс гадна, "Ted-Ed" -ийн танин мэдэхүйн цуврал бичлэгт онцолсноор 2018 онд тус усны эрчим хүчний цахилгаан станц 101.6 тэрбум кВт цахилгаан үйлдвэрлэсэн нь Хятад улсын газар нутгийн 2%-ийг нэг жилийн хугацаанд эсвэл Нью-Йорк хотыг 2 жилийн турш эрчим хүчээр бүрэн хангах хэмжээний хүчин чадалтай гэжээ. Энэ үзүүлэлт нь дэлхийн хамгийн том нүүрс болон хийн станцуудыг нийлүүлснээс илүү хол давж байна.

CYPC-ийн 2021-2025 онуудад хэрэгжүүлэх бодлогын хүрээнд эрчим хүчний бүтцийн хувьд зөвхөн усан цахилгаан станцын бизнес загварчлалаас салхи-нар-уснаас эрчим хүч үйлдвэрлэх гурвалсан бүтцэд хөрвөж, олон эрчим хүчний нэмэлт хөгжлийн загварыг бий болгоно гэсэн зорилт тавьсан нь компанийн ирээдүйн өсөлтөд чухал үр нөлөө үзүүлэх төлөвтэй байна. Харин аж үйлдвэрийн бодлогын хувьд, өмнө нь Хятад Улсын Цахилгаан Сүлжээ Корпорациар (China State Grid Corporation) дамжуулан цахилгаанаа борлуулдаг байсан бол бие даан "эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, бас борлуулах" загварийн хүрээнд өргөжин тэлж, үйлдвэрлэлийн иж бүрэн сүлжээг цогцлооход анхаарлаа хандуулан ажиллана гэжээ.

Тус компанийн хувьцааны ханш 2014 оноос хойш томоохон өсөлтийн трэндийг хадгалан арилжаалагдаж байгаа бөгөөд техник шинжилгээгээр энэ оны 7 сарын байдлаар өсөлтийн трэндийн ёроол цэгүүд дээр арилжаалагдаж байна. Иймд энэхүү өсөлтийн трэндийн ёроол цэгүүд дээр худалдан авалтаа хийж урт хугацаанд хөрөнгө оруулалт хэлбэрээр худалдан авах нь оновчтой.

Зорилтод ханш

CNY 23.94

Хувьцааны ханш

CNY 21.53

Валют

CNY

Боломжит өсөлт

11.19%

Зах зээл дээр

Зах зээлийн үнэлгээ

Дундаж арилжааны идэвх

Хувьцааны тоо ширхэг

Нээлттэй арилжаалагдаж буй

\$72.63 тэрбум

46,908,091ш

24.47 тэрбум ш

8.43 тэрбум ш

52 долоо хоногийн ханш



Харьцаа, үзүүлэлтүүд

Жил	2021	2022	2023*
Нэгж хувьцаанд ногдох ашиг	1.16	0.94	0.96
Үнэ-орлогын харьцаа (P/S)	8.57	8.82	8.79
Үнэ-ашигын харьцаа (P/E)	18.07	21.49	22.22
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	2.63	2.48	2.82
Ногдол ашгийн өгөөж	4.1%	3.67%	3.96%
Хөрөнгийн өгөөж (ROA)	7.99%	6.51%	3.97%
Өмчийн өгөөж (ROE)	14.51%	11.49%	11.43%

Бусад харьцаа үзүүлэлтүүд

Стандарт хазайлт (5 жил)	19.42%
Beta (5 жил)	0.14
Дундаж өгөөж (5 жил)	24.28%
Altman Z оноо	1.25
Ногдол ашгийн өгөөж (5 жил)	3.68%

Холбоо барих

Голомт Капитал УЦК

Судалгаа бэлтгэсэн: Хөрөнгө удирдлага.

Судалгааны газар

Хаяг: Парк Плэйс оффис, 4 давхар, 403

тоот, Чингисийн өргөн чөлөө-24

Утас: (+976) 7012-1530

Цахим хаяг: <http://golomtcapital.com/>

Email: info@golomtcapital.com

Гадаад арилжааны брокер:

(+976) 8610-3636

(+976) 8006-9977

Орлогын тайлан (сая ам.доллароор)

Жил	2021	2022	Хэвтээ шинжилгээ 2021-2022	Босоо шинжилгээ 2022
Борлуулалтын орлого	55,646	52,060	-6.4%	100.00%
Нийт зардал	21,113	22,233	5.3%	42.7%
Нийт ашиг	34,533	29,827	-13.6%	57.29%
Хүү болон татварын өмнөх орлого	37,212	30,588	-17.8%	58.76%
Татварын өмнөх орлого	32,409	26,313	-18.8%	50.54%
Татвар	5,923	4,664	-21.2%	8.96%
Цэвэр ашиг	26,273	21,309	-18.9%	40.93%

Баланс (сая ам.доллароор)

Эргэлтийн хөрөнгө	17,923	15,302	-14.6%	4.68%
Эргэлтийн бус хөрөнгө	310,640	311,966	0.426%	95%
Нийт хөрөнгө	328,563	327,268	-0.39%	100.00%
Эргэлтийн өр төлбөр	53,406	52,458	-1.77%	16%
Эргэлтийн бус өр төлбөр	84,869	79,056	-6.85%	24.16%
Нийт өр төлбөр	138,275	131,514	-4.89%	40.19%
Нийт эздийн өмч	181,064	185,488	2.44%	56.68%

Мөнгөн гүйлгээ (сая ам.доллароор)


Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	35,732	30,913	-13.49%	-
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ	(6,565)	(4,093)	37.65%	-
Санхүүжилтийн мөнгөн гүйлгээ	(28,380)	(27,584)	2.8%	-
Нийт өөрчлөлт	787	(764)	-197.08%	-
Цэвэр мөнгөн гүйлгээ	32,259	26,042	-19.27%	-

Жил	2020	2021	2022	2023*
-----	------	------	------	-------

Харьцаа үзүүлэлтүүд


Эргэлтийн харьцаа	0.42	0.5	0.29	0.56
Нийт эздийн өмчийн өгөөж	15.28%	14.51%	11.49%	11.43%
Нийт хөрөнгийн өгөөж	7.95%	8.00%	6.51%	4.42%
Хөрөнгийн эргэц	0.17	0.17	0.16	0.12
Нийт ахиуц ашиг	0.63	0.62	0.57	0.63
Цэвэр ахиуц ашиг	0.46	0.47	0.41	0.45
Санхүүгийн хөшүүрэг	1.92	1.81	1.76	2.97
Өр ба хөрөнгийн харьцаа	0.58	0.56	0.60	1.8
Үнэ-орлогын харьцаа (P/S)	6.57	8.57	8.82	8.79
Үнэ-ашигийн харьцаа (P/E)	14.37	18.07	21.49	22.22
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	2.20	2.63	2.48	2.82
Нэгж хувьцаанд ногдох ашиг	1.19	1.16	0.94	0.96

Yangtze Power компанийн хувьцааны ханшийн өсөлтийн хувийг Shanghai Composite индексстэй харьцуулсанаар




Салбарын харьцуулалт

Салбарын Top-10 компанитай харьцуулснаар




Түүхэн үнэлгээ



Нэгж хувьцаанд ногдох ашгийн өсөлт

DUK, EBR, VER.VI JPPOWE.NS, INE.TO



ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТ

Хөрөнгө оруулалтын позицын өөрчлөлт

Худалдан авсан		Зарсан	
Хөрөнгө оруулагч	Сая ширхэг	Хөрөнгө оруулагч	Сая ширхэг
China Three Gorges Corporation	+460.96	Sunshine Life Insurance Corporation Limited	-148.59
Sichuan Energy Industry Investment Group Co., Ltd.	+159.53	China Asset Management Co., Ltd.	-0.17
Yunnan Provincial Energy Investment Group Co., Ltd.	+93.05	BlackRock Institutional Trust Company, N.A.	-1.51
JP Morgan Asset Management (Asia Pacific) Limited	+2.78	BlackRock Advisors (UK) Limited	-1.16
CPP Investment Board[Activist]	+50.40	Allianz Global Investors Asia Pacific Limited	-0.00
Huatai-PineBridge Fund Management Co., Ltd.	+20.80	BlackRock Asset Management North Asia Limited	-0.14
J.P. Morgan Asset Management (Singapore) Limited	+12.27	iShares Semiconductor ETF	-0.26
The Vanguard Group, Inc.	+0.69	iShares Russell	-0.07
China Universal Asset Management Co., Ltd.	+14.13	iShares MSCI USA Value Factor ETF	-0.37
Vanguard High Dividend Yield Index Fund Admiral	+0.08	DFA U.S. Large Cap Value Portfolio	-2.94
			Refinitiv

Шинжээчдийн таамаглал

Олон улсын хөрөнгө оруулалтын сангуудын ханшийн таамаглал

Ханшийн зорилт гаргасан	Зорилтот ханш	Одоогийн ханшаас %	Зөвлөмж	Огноо
China International Capital Corporation (Hong Kong) Limited	24.00	13.05%	Худалдан авах	5/12/2023
Huatai Securities	30.40	43.19%	Худалдан авах	5/4/2023
Citic Securities	26.40	24.35%	Худалдан авах	4/26/2023
Guosen Securities	24.77	-16.65%	Худалдан авах	11/6/2022
Southwest Securities	26.88	26.61%	Худалдан авах	6/1/2022
Credit Suisse- Non-Japan Asia	30	41.31%	Худалдан авах	11/1/2021
Undisclosed	24.50	15.40%	Хадгалах	5/30/2023
Undisclosed	28.20	32.83%	Худалдан авах	3/6/2022
Undisclosed	28.50	34.24%	Худалдан авах	8/12/2018
China Merchants Securities Co.,Ltd	-	-	Худалдан авах	6/15/2023
Sinolink Securities Co., Ltd	-	-	Худалдан авах	5/2/2022
CJS International	-	-	Худалдан авах	1/31/2022
Дундаж	27.10	27.64%		
Мэдиан	26.64	25.47%		

Refinitiv

ТЕХНИК ШИНЖИЛГЭЭ

Golomt_Capital published on TradingView.com, Jul 31, 2023 14:51 UTC+8



Golomt_Capital published on TradingView.com, Jul 28, 2023 17:14 UTC+8



Сүүлийн 8 сар үргэлжилсэн тренд ерөнхий өсөлтийг харуулж байна. Өсөлтийн эхний бай 21.34 ам.доллар ба цаашлаад ирэх оны 7 сард 23.94 ам.доллар хүрэх боломжтой. Харин худалдан авалт хийх тохиромжтой цэг нь 8 сарын 10 буюу Пүрэв гаригт 20.65 – 20.78 ам.доллар дээр байрлаж байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээч болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно